



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2018.08.17 № 36

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЦОГОО  
ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Үндсэн хуульд “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” Төрийн албаны тухай хуульд Үндсэн хуульд тусгалаа олсон 5 зарчмаас гадна захирах, захирагдах ёс, ил тод байх, ард түмэнд үйлчлэх, мэргэшсэн тогтвортой байх зэрэг тусгай зарчмуудыг хуульчилсан.

Төрийн албан хаагч нь өөрийн үйл ажиллагаандаа хууль дээдлэх зарчмыг удирдлага болгон төрийн үйлчилгээг иргэнд шуурхай чирэгдэлгүй үзүүлэх нь тэдний хуулиар хүлээсэн үндсэн үүрэг нь юм.

Төрийн байгууллагын удирдах болон үйлчилгээний албан тушаалтнуудын дунд өөрсдийн албан тушаал, эрх мэдлээ ашиглан хувьдаа ашиг хонжоо олох, өмч хөрөнгө идэж шамшигдуулах, авлига, хээл хахууль авах, танил талын хүрээнд асуудлыг шийдэх, ах дүү, хамаатан саднаа болон мэргэжлийн бус хүнийг албан тушаалд томилох зэрэг зөрчил доголдол газар авч буй нь Монгол төрийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, иргэд төрийн албанд итгэх итгэл алдарч байна.

Төрийн албан хаагчид цэвэр ариун ёс суртахуунтай, албан тушаал, ажил мэргэжлийнхээ ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажилладаг болгоход төрийн албаны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал чухал ач холбогдолтой. Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг буй болгож чадсан төр илүү цэвэршдэг тухай судлаачид авч үзсэн байдаг.

Сүүлийн он жилүүдэд Монгол төрийн алба дотроо карьерын зарчмаар өсч дэвждэг, албан тушаал дэвшүүлэн томилдог зарчим бүдгэрч байгаагаас болж эх орон, улс үндэстний төлөө ямар нэг шуналын сэтгэлгүй чин шударгаар ажилладаг албан хаагчид үлэмж хэмжээгээр буурч байгаа нь манай улсын дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдлийг бий болгох магадлалтай байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Төрийн албаны зөвлөл нь хараат бус бие даасан байгууллага болохыг төрийн албаны хуулиар тодохойлсон байна. Зөвлөл нь хуульд заасан хараат бус байдлаар ажиллаж чадаж буй эсэх,

0000000086

2. Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйл Зөвлөлийн бүрэн эрх хэсгийн 35.1.2-т "...төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил арга зүйн удирдлагаар хангах... шалган зааварлах, зөрчлийг арилгуулах, хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, энэ хуулийн 39.1-д заасан ... албан тушаалтны буруутай үйл ажилагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах гэх мэт чиг үүрэг, эрхтэй байна.

- Зөвлөл нь төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх талаар ямар бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэх.
- Төрийн албаны хууль зөрчсөн зөрчлийг арилгуулахаар ямар байгууллагуудад хугацаатай үүрэг өгч гүйцэтгэлд нь хяналт тавьсан. Хууль дээдлэх зарчмыг гажуудуулдаг байдал аль төвшний албан тушаалтнууд дээр илүүтэй байгаа.
- Хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийн дагуу албан тушаалтны буруутай үйл ажилагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаж ажилласан эсэх. /сүүлийн таван жилийн байдлаар судалгааг гаргаж танилцуулага бичигдсэн байна./

3. Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлээр хориглогдсон хуулийн заалтууд зөрчигдөж буй эсэх, зөрчигдөж байгаа бол аль төвшинд зөрчлийг гаргадаг.

4. Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг бодитойгоор тодорхойлж төрийн байгууллага, албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн дэмжлэгийг үзүүлж буй байдал.


5. Ажлаас хуулийн үндэслэлгүйгээр халагдсан албан хаагчдыг албан тушаалд нь эгүүлэн томилсон шүүхийн шийдвэр бүрэн биелэгддэг эсэх. /шүүхийн шийдвэрээр албан тушаалдаа томилогдсон боловч өнөөг хүртэл тухай байгууллага ажилд нь эгүүлэн томилоогүй удирдах болон гүйцэтгэх төвшний иргэн байгаа бол салбар бүрээр нь нэр, албан тушаалаар нь гаргаж ирүүлэх/

6. Төрийн албан хаагчдын зүгээс гэмт хэрэг үйлдэж, шүүхээр буруутай нь тогтоогддог байдлын өсөлт, бууралт. Улсад учруулсан хохирлын хэмжээ.

7. Албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учруулж буй хохирлын хэмжээг сүүлийн 5 жилээр, он оноор гаргаж холбогдох тайлбарыг хийх.

Асуулгыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд албан бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ЭНХ-АМГАЛАН